



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

### Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 13.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамж, сэтгэл зүйн эрүүл мэндийг үнэлэх, зөвлөгөө өгөх, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулахыг Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн (Ш.Ундармаа)-д даалгасугай.

2. Албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамж, сэтгэл зүйн эрүүл мэндийг үнэлэх, зөвлөгөө өгөх, сургалтад хамруулахад шаардагдах 425.000 (дөрвөн зуун хорин таван мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ